



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/02/НА-СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261885 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Нарангэрэл
Утас: 261740 Цахим хаяг: narangerelb@audit.gov.mn
Аудитор: Ч.Дашдаваа
Утас: 261618 Цахим хаяг: dashdavaach@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга	12
3.5.1 Мөнгөн хөрөнгө	12
3.5.2 Авлага.....	13
3.5.3 Урьдчилгаа.....	14
3.5.4 Бараа материал.....	14
3.5.5 Үндсэн хөрөнгө.....	15
3.5.6 Өр төлбөр	15
3.5.7 Засгийн газрын хувь оролцоо	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Харьяа байгууллагууд	19
4.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч	19
4.2.1 Албан шаардлага	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20
5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл.....	20
5.2 Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл.....	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ШУА	Шинжлэх ухааны академи
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН
ЭРДЭМТЭН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Б.АВИД ТАНАА

2022.03.25 № 01/717
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Шинжлэх ухааны академийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Шинжлэх ухааны академийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар залруулагдаагүй 499.1 сая төгрөгийн зөрчил илэрч, тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, Нийцсэн бөгөөд зохистой байх, Эрх ба үүрэг, Тохиолдсон байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САРАНСҮХ

2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,083,898.5	2,791,765.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	108,735.5	81,045.4
33	АВЛАГА	517,003.6	912,495.3
34	УРЬДЧИЛГАА	348,833.7	470,648.4
35	БАРАА МАТЕРИАЛ	1,109,325.7	1,327,576.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	35,120,932.7	38,893,368.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	35,120,932.7	38,893,368.6
39200	Биет хөрөнгө	29,114,862.1	32,290,437.9
39300	Биет бус хөрөнгө	6,006,070.6	6,602,930.7
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	37,204,831.2	41,685,133.7
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	49,050.5	187,485.5
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	49,050.5	187,485.5
41300	Өглөг	7,154.1	8,338.6
41400	Урьдчилж орсон орлого	41,896.4	179,146.9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	37,155,780.7	41,497,648.2
51	Засгийн газрын хувь оролцоо	37,155,780.7	41,497,648.2
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	23,352,487.6	23,352,487.7
51200	Хуримтлагдсан үр дүн	3,492,158.3	7,834,268.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10,311,134.8	10,310,892.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	37,204,831.2	41,685,133.7

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	32,907,253.7	36,881,782.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,186,842.6	7,630,597.4
120	Нийтлэг татварын бус орлого	3,102,129.4	5,160,928.1
122	Тусламжийн орлого	2,084,713.2	2,469,669.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	27,720,411.1	29,251,184.8
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	29,887,059.3	32,480,014.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	29,887,059.3	32,480,014.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	28,246,656.8	30,531,747.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,548,665.4	16,302,182.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,054,056.6	2,074,537.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	569,579.3	583,549.2
2104	Хангамж, бараа материалын зардал	440,842.2	789,849.4
2105	Нормативт зардал	-	1,647.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	424,050.3	427,004.0
2107	Томилолт, зочны зардал	356,144.5	337,339.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,160,523.8	4,495,703.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,692,794.7	5,519,934.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,640,402.5	1,948,266.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	3,020,194.4	4,401,767.9
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	73.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	544,350.0	39,145.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	2,475,844.4	4,362,695.8

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	34,630,095.5	-	34,630,095.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	222,491.7	-	222,491.7
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	34,852,587.2	-	34,852,587.2
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(172,650.9)	-	(172,650.9)
9	Тайлант үеийн үр дүн	2,475,844.5	-	2,475,844.5
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	37,155,780.8	-	37,155,780.8
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(20,585.6)	-	(20,585.6)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	37,135,195.2	-	37,135,195.2
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(242.8)	-	(242.8)
19	Тайлант үеийн үр дүн	4,362,695.8	-	4,362,695.8
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	41,497,648.2	-	41,497,648.2

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	30,360,624.3	32,225,781.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,088,773.7	2,470,279.4
120	Нийтлэг татварын бус орлого	4,060.5	610.2
122	Тусламжийн орлого	2,084,713.2	2,469,669.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	28,271,850.6	29,755,502.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	28,555,811.4	30,770,127.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	28,555,811.4	30,770,127.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,540,942.9	28,251,431.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,389,253.8	16,191,185.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,040,413.4	2,060,553.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	570,470.3	581,362.7
2104	Хангамж, бараа материалын зардал	442,672.7	656,320.4
2105	Нормативт зардал	12,582.0	6,997.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	631,384.1	641,518.9
2107	Томилолт, зочны зардал	369,821.2	391,300.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,568,728.0	5,197,912.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,515,617.4	2,524,279.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,014,868.5	2,518,696.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,804,812.9	1,455,654.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,062,679.0	1,483,344.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,062,679.0	1,483,344.4
2200	Дотоод эх үүсвэрээр	2,062,679.0	1,483,344.4
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(2,062,679.0)	(1,483,344.4)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(257,866.1)	(27,690.1)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	366,601.6	108,735.5
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	108,735.5	81,045.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код:	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	23,671,917,500.00	22,341,364,461.91	1,330,553,038.09	94.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	23,671,917,500.00	22,341,364,461.91	1,330,553,038.09	94.4
210	БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	23,063,911,000.00	21,735,640,350.71	1,328,270,649.29	94.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,464,696,100.00	15,552,873,631.96	911,822,468.04	94.5
210101	Үндсэн цалин	12,050,473,600.00	11,764,585,055.25	285,888,544.75	97.6
210102	Нэмэгдэл	2,788,824,800.00	2,500,059,494.52	288,765,305.48	89.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,625,397,700.00	1,287,886,964.19	337,510,735.81	79.2
210104	Урамшуулал	-	342,118.00	(342,118.00)	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,251,434,800.00	2,012,161,420.08	239,273,379.92	89.4
210201	Тэтгэврийн даатгал	1,577,973,100.00	1,426,916,198.47	151,056,901.53	90.4
210202	Тэтгэмжийн даатгал	168,365,500.00	159,508,814.02	8,856,685.98	94.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	134,692,400.00	124,874,166.80	9,818,233.20	92.7
210204	Ажилгүйдлийн даатгал	33,673,000.00	27,207,495.81	6,465,504.19	80.8
210205	Эрүүл мэндийн даатгал	336,730,800.00	273,654,744.98	63,076,055.02	81.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	602,507,400.00	572,054,420.37	30,452,979.63	94.9
210301	Гэрэл, цахилгаан	290,022,300.00	298,322,532.39	(8,300,232.39)	102.9
210302	Түлш, халаалт	266,573,800.00	232,033,896.36	34,539,903.64	87.0
210303	Цэвэр, бохир ус	43,241,800.00	41,360,491.62	1,881,308.38	95.6
210304	Байрны түрээс	2,669,500.00	337,500.00	2,332,000.00	12.6
2104	Хангамж, бараа материалын зардал	299,409,000.00	294,032,287.59	5,376,712.41	98.2
210401	Бичиг хэрэг	26,840,400.00	30,732,802.00	(3,892,402.00)	114.5
210402	Тээвэр, шатахуун	18,643,700.00	17,433,547.00	1,210,153.00	93.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	42,406,900.00	42,897,535.59	(490,635.59)	101.2
210404	Ном, хэвлэл	148,827,000.00	136,417,260.00	12,409,740.00	91.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,323,700.00	9,101,828.00	221,872.00	97.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	53,367,300.00	57,449,315.00	(4,082,015.00)	107.6
2105	Нормативт зардал	8,600,000.00	6,997,000.00	1,603,000.00	81.4
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,000,000.00	4,997,000.00	3,000.00	99.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,600,000.00	2,000,000.00	1,600,000.00	55.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,629,479,800.00	1,601,510,454.57	27,969,345.43	98.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,208,496,100.00	1,195,403,076.57	13,093,023.43	98.9

Шинжлэх ухааны академийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210602	Тавилга	1,727,200.00	499,900.00	1,227,300.00	28.9
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	24,927,000.00	24,742,190.00	184,810.00	99.3
210604	Урсгал засвар	394,329,500.00	380,865,288.00	13,464,212.00	96.6
2107	Томилолт, зочны зардал	114,608,500.00	109,886,712.61	4,721,787.39	95.9
210702	Дотоод албан томилолт	114,608,500.00	109,886,712.61	4,721,787.39	95.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,569,678,500.00	1,489,351,860.52	80,326,639.48	94.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,476,228,300.00	1,432,443,000.52	43,785,299.48	97.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	35,480,000.00	27,880,000.00	7,600,000.00	78.6
210803	Даатгалын үйлчилгээ	4,238,200.00	3,502,234.00	735,966.00	82.6
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,284,100.00	2,218,377.00	1,065,723.00	67.5
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	664,000.00	375,000.00	289,000.00	56.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00	1,500,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	47,283,900.00	21,433,249.00	25,850,651.00	45.3
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,000,000.00	-	1,000,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	123,496,900.00	96,772,563.01	26,724,336.99	78.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,461,200.00	1,295,800.00	165,400.00	88.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	122,035,700.00	95,476,763.01	26,558,936.99	78.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	608,006,500.00	605,724,111.20	2,282,388.80	99.6
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	11,429,300.00	11,128,654.20	300,645.80	97.4
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	11,429,300.00	11,128,654.20	300,645.80	97.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	596,577,200.00	594,595,457.00	1,981,743.00	99.7
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,204,500.00	8,176,100.00	28,400.00	99.7
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	561,168,900.00	561,168,900.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,203,800.00	25,250,457.00	1,953,343.00	92.8
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	23,671,917,500.00	22,340,303,353.91	1,331,614,146.09	94.4
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	23,671,917,500.00	22,339,693,353.91	1,332,224,146.09	94.4
310001	Улсын төсвөөс санхүүжих	23,671,917,500.00	22,339,693,353.91	1,332,224,146.09	94.4
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	610,000.00	(610,000.00)	
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	610,000.00	(610,000.00)	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,061,108.00	(1,061,108.00)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	2,427	2,447	(20)	100.8
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	15	15	-	100.0

Шинжлэх ухааны академийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

610001	Төсвийн байгууллага	15	15	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,206	1,216	(10)	100.8
620001	Удирдах ажилтан	15	21	(6)	140.0
620002	Гүйцэтгэх ажилтан	993	1,014	(21)	102.1
620003	Үйлчлэх ажилтан	198	181	17	91.4
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1,206	1,216	(10)	100.8
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	1,023	1,041	(18)	101.8
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	4	3	1	75.0
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1	1	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	178	171	7	96.1

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код:	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		6,100,042,279.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ		6,039,108,751.51
210	БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		5,441,903,213.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		638,311,566.83
210101	Үндсэн цалин		296,382,194.82
210102	Нэмэгдэл		1,400,800.00
210105	Гэрээт ажлын хөлс		340,528,572.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		48,392,348.99
210201	Тэтгэврийн даатгал		48,392,348.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		9,308,300.00
210301	Гэрэл, цахилгаан		9,308,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал		364,608,324.82
210401	Бичиг хэрэг		10,903,694.00
210402	Тээвэр, шатахуун		87,544,550.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		7,101,932.80
210404	Ном, хэвлэл		223,900,904.85
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		163,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		34,993,643.17
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		139,857,288.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		119,612,980.00
210604	Урсгал засвар		20,244,308.00
2107	Томилолт, зочны зардал		281,414,224.68
210701	Гадаад албан томилолт		10,284,000.00
210702	Дотоод албан томилолт		271,130,224.68
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		3,911,151,259.84
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		3,910,056,259.84
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		1,095,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		48,859,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		2,224,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		46,635,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		597,205,538.35
2132	Бусад урсгал шилжүүлэг		3,385,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		3,385,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		593,820,538.35
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг		593,820,538.35
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		60,933,528.00
2200	Дотоод эх үүсвэрээр		60,933,528.00
224001	Стратегийн нөөц хөрөнгө		-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		60,933,528.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		-
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		6,100,042,279.51
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		6,100,042,279.51
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		1,849,130,126.92
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,081,243,310.07
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		2,169,668,842.52

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Шинжлэх ухааны академийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад төсвийн хэмнэлтийн талаар гаргасан ЗГ-ын тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлж, батлагдсан төсвийг зохистой удирдаж, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Үндэсний аудитын газрын Аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор Б.Нарангэрэл, аудитор Ч.Дашдаваа нар 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн хооронд гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Сарансүх нар хэрэгжүүлсэн.

Шинжлэх ухааны академийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 1/65 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Шинжлэх ухааны академийн үйл ажиллагааны зорилго нь олон улсад нэр хүндтэй, өрсөлдөх чадвартай шинжлэх ухаан, технологийн үндэсний төв байгууллага байхад оршино. Шинжлэх ухааны академийн үйл ажиллагааны стратегийн зорилтын хүрээнд дараах чиг үүргийг гүйцэтгэж байна. Үүнд:

- Шинжлэх ухааны Академийн менежментийн чадавхыг бэхжүүлэх;
- Шинжлэх ухаан технологийн тэргүүлэх чиглэлийг шинэчлэн тодорхойлж, судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг нийгэмд түгээн дэлгэрүүлэх;
- Хүний нөөцийг хөгжүүлж, хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх;
- Судалгаа боловсруулалтын таатай орчин бүрдүүлэн хөгжүүлэх;
- Олон эх үүсвэр бүхий санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх;
- Инновацийн орчин, соёлыг төлөвшүүлж, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэх;
- Гадаад харилцаа, хамтын ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль тогтоомж, бодлого, чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг шинэчлэн батлах тухай 190 дүгээр тушаал;
- ЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол;
- ЗГ-ын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоол;
- Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

БШУЯ-ны Хяналт шинжилгээ үнэлгээний газраас дотоод аудитын чиглэлээр хяналт шалгалт хийгээгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын зорилго оршино.

Шинжлэх ухааны академийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил, гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг төсвийн тухай хуулийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн дагуу иж бүрэн бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 32,519.2 сая төгрөгөөс 1 хувиар буюу 325.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Шинжлэх ухааны академийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,480.3 сая төгрөгөөр буюу 12.0 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө данснүүдэд материаллаг өөрчлөлт гарсан байна.

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 81.0 сая төгрөг болж, 27.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	108,735.5	81,045.4	(27,690.1)
Дүн			

Эх сурвалж: Шинжлэх ухааны академийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 81.0 сая төгрөг нь Одон орон геофизикийн хүрээлэнгийн арилжааны банкин дахь дансанд байршиж байна.

Аудитын илрүүлэлт: Шинжлэх ухааны академийн харьяа байгууллагуудын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар мөнгөн хөрөнгөтэй холбоотой дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Шинжлэх ухааны академи нь докторын зэрэг хамгаалах ажлын хэсгийн гишүүдэд цалин олгохдоо 3.5 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутган тооцоогүй, ХХОАТ-ыг 0.2 сая төгрөгөөр илүү суутгаж, гарт олгох цалинг 1.5 сая төгрөгөөр илүү олгосон.
- Математик тоон технологийн хүрээлэн төслийн цалингаас 9.9 сая төгрөгийн НДШ суутгаагүй.

- Түүх угсаатны зүйн хүрээлэн нь нэр бүхий 20 ажилтны цалин, ээлжийн амралтыг давхардуулан 6.3 сая төгрөг илүү олгосон. 2020 оны санхүүгийн тайлангийн аудитыг үе шатны ажлыг хэсэгчлэн хийх хуваарьтай байхад аудитын хуулийн этгээдээр санхүүгийн тайлангийн аудитыг баталгаажуулж 2.5 сая төгрөг шилжүүлсэн.
- Хими, хими технологийн хүрээлэн нь үндсэн цалин, амралтын цалин давхардуулан 1.7 сая төгрөг илүү олгосон.
- Археологийн хүрээлэн нь төслийн цалин хөлснөөс 47.6 сая төгрөгийн Нийгмийн даатгалын шимтгэл суутган тооцоогүй, 2.3 сая төгрөгийн ХХОАТ илүү суутгасан. 2020 оны санхүүгийн тайлангийн аудитыг үе шатны ажлыг хэсэгчлэн хийх хуваарьтай байхад аудитын хуулийн этгээдээр санхүүгийн тайлангийн аудитыг баталгаажуулж 1.0 сая төгрөг шилжүүлсэн.
- Геологийн хүрээлэн нь төслийн цалингийн зардалд 13.7 сая төгрөг зарцуулж, ажил олгогчоос төлөх НДШ-ийг ажилтны цалингаас суутган төлсөн. 2020 оны санхүүгийн тайлангийн аудитыг үе шатны ажлыг хэсэгчлэн хийх хуваарьтай байхад аудитын хуулийн этгээдээр санхүүгийн тайлангийн аудитыг баталгаажуулж 1.5 сая төгрөг шилжүүлсэн.
- Одон орон, геофизикийн хүрээлэн нь бараа үйлчилгээний бусад зардлын ангиллаас үндсэн орон тооны ажилтнуудад үндсэн цалингаас гадна 1,020.9 сая төгрөгийн цалин олгосон.
- Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн нь 2020 оны санхүүгийн тайлангийн аудитыг үе шатны ажлыг хэсэгчлэн хийх хуваарьтай байхад аудитын хуулийн этгээдээр санхүүгийн тайлангийн аудитыг баталгаажуулж 1.5 сая төгрөг шилжүүлсэн.

3.5.2 Авлага

Авлага дансны үлдэгдэл 912.5 сая төгрөг болж, 395.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Авлагын үлдэгдэл

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбогдсон авлага	1,338.0	2,806.6	1,468.6
Төлбөртэй үйлчилгээний авлага	36,802.0	133,393.7	96,591.7
Татаас, санхүүжилтийн авлага	374,466.0	573,502.0	199,036.1
Байгууллагаас авах авлага	104,397.7	202,792.9	98,395.3
Дүн	517,003.6	912,495.3	395,491.7

Эх сурвалж: Шинжлэх ухааны академийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэл 395.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд төлбөртэй үйлчилгээний авлага Палеонтологийн хүрээлэн 60.0 сая, Философийн хүрээлэн 73.4 сая, татаас санхүүжилтийн авлага Түүх, угсаатны зүйн хүрээлэн 48.9 сая, Биологийн хүрээлэн 74.1 сая, Газарзүй, гео-экологийн хүрээлэн 190.6, Хими, хими технологийн хүрээлэн 28.6 сая, Физик технологийн хүрээлэн 33.8 сая, Шинжлэх ухааны академи 42.8 сая, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн 37.3 сая төгрөгийн авлага нь дансны үлдэгдэл нэмэгдэхэд голлон нөлөөлсөн.

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай авлага байхгүй байна.

Шинжлэх ухааны академийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар Шинжлэх ухааны академи, 14 хүрээлэн 912.5 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Үүнд:

- Математик, тоон технологийн хүрээлэн 0.1 сая, Газарзүй, гео-экологийн хүрээлэн 0.4 сая, Хими, хими технологийн хүрээлэн 1.8 сая, Олон улсын харилцааны хүрээлэн 0.2 сая, Хэл зохиолын хүрээлэн 0.1 сая төгрөгийн ажиллагсадтай холбоотой авлага;
- Палеонтологийн хүрээлэн 60.0 сая, Философийн хүрээлэн 73.4 сая төгрөгийн төлбөртэй үйлчилгээний авлага;
- Математик, тоон технологийн хүрээлэн 14.4 сая, Палеонтологийн хүрээлэн 4.5 сая, Түүх, угсаатны зүйн хүрээлэн 48.9 сая, Биологийн хүрээлэн 74.1 сая, Газарзүй, гео-экологийн хүрээлэн 190.6 сая, Философийн хүрээлэн 7.0 сая, Хими, хими технологийн хүрээлэн 28.6 сая, Физик технологийн хүрээлэн 33.8 сая, Одон орон, геофизикийн хүрээлэн 24.7 сая, Шинжлэх ухааны академи 42.8 сая, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн 37.3 сая, Геологийн хүрээлэн 29.6 сая, Археологийн хүрээлэн 20.4 сая, Хэл зохиолын хүрээлэн 16.6 сая төгрөгийн татаас санхүүжилтийн авлага;
- Түүх, угсаатны зүйн хүрээлэн 28.0 сая, Хими, хими технологийн хүрээлэн 32.2 сая, Одон орон, геофизикийн хүрээлэн 52.1 сая, Шинжлэх ухааны академи 0.2 сая, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн 8.7 сая, Геологийн хүрээлэн 9.9 сая, Археологийн хүрээлэн 41.8 сая, Хэл зохиолын хүрээлэн 30.0 сая төгрөгийн байгууллагаас авах авлагатай байна.

Аудитын илрүүлэлт

- Түүх, угсаатны зүйн хүрээлэн нь тайлант хугацааны эцэст худалдан авалтын гэрээ байгуулж, 28.0 сая төгрөгийн авлага үүсгэсэн.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны үлдэгдэл 470.6 сая төгрөг болж, 121.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	344,083.2	464,447.9	120,364.7
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	4,750.5	6,200.5	1,450.0
Дүн	348,833.7	470,648.4	121,814.7

Эх сурвалж: Шинжлэх ухааны академийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа данс тайлант оны эцэст 470.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнд:

- Шинжлэх ухааны академи 16.6 сая, Математик, тоон технологийн хүрээлэн 19.7 сая, Палеонтологийн хүрээлэн 15.7 сая, Түүх, угсаатны зүйн хүрээлэн 41.0 сая, Хими, хими технологийн хүрээлэн 306.8 сая, Физик технологийн хүрээлэн 41.0 сая, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн 23.5 сая төгрөгийн урьдчилж гарсан зардлын үлдэгдэл.
- Палеонтологийн хүрээлэн 4.2 сая, Шинжлэх ухааны академи 0.6 сая төгрөгийн урьдчилгаа тооцоо дансны үлдэгдэл.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 1,327.6 сая төгрөг болж, 218.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	334,411.9	403,965.2	69,553.3
Бэлэн бүтээгдэхүүн	4,846.1	4,846.1	-
Бичиг хэргийн материал	40,465.5	54,549.1	14,083.6
Аж ахуйн материал	390,594.1	427,181.6	36,587.5
Сэлбэг хэрэгсэл	31,977.0	36,695.6	4,718.6
Түлш, шатах тослох материал	9,429.7	49,783.3	40,353.6
Барилгын засварын материал	19,266.0	7,236.6	(12,029.4)
Бусад хангамжийн материал	278,335.4	343,318.5	64,983.1
Дүн	1,109,325.7	1,327,576.0	218,250.3

Эх сурвалж: Шинжлэх ухааны академийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд бараа материал 2,211.5 сая төгрөгөөр нэмэгдэж /худалдан авсан 2,139.9 сая, шилжүүлж авсан 29.6 сая, хандиваар 15.7 сая, бусад 26.3 сая/, 1,993.3 сая төгрөгөөр буурсан /зарцуулсан 1,854.5 сая, балансаас балансад шилжүүлсэн 94.0 сая, бусад 44.8 сая/ байна.

Тайлант хугацаанд тусгай зориулалтын материал Физик, технологийн хүрээлэн 218.5 сая, Одон орон, геофизикийн хүрээлэн 60.9 сая, Археологийн хүрээлэн 21.4 сая, бусад хангамжийн материал Түүх, угсаатны зүйн хүрээлэн 73.7 сая, Биологийн хүрээлэн 52.1 сая, Шинжлэх ухааны академи 61.7 сая, Археологийн хүрээлэн 50.5 сая, Хэл зохиолын хүрээлэн 41.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь бараа материалын өсөлтөд голлон нөлөөлсөн.

Бараа материалын үлдэгдэлд тайлант оны эцэст харьяа хүрээлэнгүүдийн хэвийн үйл ажиллагааг хангахад ашиглаж буй 1,327.6 сая төгрөгийн үлдэгдэл байгаа ба хэрэгцээ шаардлагагүй ашиглах боломжгүй бараа материалын нөөц байхгүй байна.

Тайлант оны эцэст 22.4 сая төгрөгийн шатах тослох материалын нөөц үүсгэжээ. Үүнд: Түүх, угсаатны зүйн хүрээлэн 11.9 сая, Газарзүй, гео-экологийн хүрээлэн 0.8 сая, Хими, хими технологийн хүрээлэн 1.1 сая, Одон орон, геофизикийн хүрээлэн 2.4 сая, Шинжлэх ухааны академи 0.5 сая, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн 9.1 сая, Геологийн хүрээлэн 1.2 сая, Археологийн хүрээлэн 22.8 сая төгрөгийн түлш, шатах тослох материалын үлдэгдэлтэй.

Аудитын илрүүлэлт

- Биологийн хүрээлэн нь үндсэн хөрөнгийн шинж чанартай 5 нэр төрлийн нийт 4.3 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн.
- Түүх, угсаатны зүйн хүрээлэн нь 8.7 сая төгрөгийн шатахуун талон худалдан авалт хийж түлш шатах тослох материалын дансанд 11.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй.
- Археологийн хүрээлэн тайлант оны эцэст 20.0 сая төгрөгийн шатахууны талон худалдан авч хангамжийн материалын үлдэгдлээр тайлагнасан.
- Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн тайлант оны эцэст 9.1 сая төгрөгийн шатахууны талон худалдан авч хангамжийн материалын үлдэгдлээр тайлагнасан.

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 47,988.3 сая төгрөг болж, 4,522.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	37,063,477.1	40,914,705.8	3,851,228.7
Барилга, байгууламж, орон сууц	20,457,032.0	24,027,618.7	3,570,586.7
Авто-тээврийн хэрэгсэл	615,490.5	646,567.5	31,077.0
Машин, тоног төхөөрөмж(компьютер)	11,977,265.7	12,296,248.2	318,982.5
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,460,766.2	1,426,326.0	(34,440.2)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	2,103,231.0	2,103,231.0	
Бусад үндсэн хөрөнгө	202,848.6	164,899.8	(37,948.8)
Дуусаагүй барилга байгууламж	3,600.0	3,600.0	
Ном	243,243.1	246,214.6	2,971.5
Биет бус хөрөнгө	6,402,641.3	7,073,592.0	670,950.7
Программ хангамж	676,196.4	675,687.1	(509.3)
Бусад биет бус хөрөнгө	5,726,444.9	6,397,904.9	671,460.0
Дүн	43,466,118.4	47,988,297.8	4,522,179.4

Эх сурвалж: Шинжлэх ухааны академи 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө 6,636.6 сая төгрөгөөр нэмэгдэж /шилжүүлэн авсан 1.0 сая, хандиваар 40.4 сая, худалдан авсан 1,483.3 сая, бусад 5,111.9 сая/, 2,114.4 сая төгрөгөөр буурсан /акталсан 2,082.5 сая, балансаас балансад шилжүүлсэн 31.9 сая, тайлант хугацааны элэгдлийн зардал 2,826.1 сая/ байна.

Аудитын илрүүлэлт:

- Хими, хими технологийн хүрээлэн нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 0.5 сая төгрөгөөр илүү тооцож тайланд тусгасан. ТӨБЗГ-ын үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах тогтоолын дагуу жагсаалтаас 6.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хасахдаа данснаас илүү хассан.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны үлдэгдэл 187.5 сая төгрөг болж, 138.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбоотой өглөг	-	129.0	129.0
Бараа, үйлчилгээний зардлын өглөг	-	835.9	835.9
Байгууллагад төлөх өглөг	6,777.5	3,758.7	(3,018.8)
Хувь хүмүүст өгөх өглөг	376.6	3,615.0	3,238.4
Бусад урьдчилж орсон орлого	41,896.4	179,146.9	137,250.5
Дүн	49,050.5	187,485.5	138,435.0

Эх сурвалж: Шинжлэх ухааны академи 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 0.1 сая төгрөгийн барилгын ажиллагсадтай холбоотой өглөг, 0.8 сая төгрөгийн бараа, үйлчилгээний зардлын өглөг, 3.8 сая төгрөгийн байгууллагад төлөх өглөг, 3.6 сая төгрөгийн хувь хүмүүст өгөх өглөг, 179.1 сая төгрөгийн бусад урьдчилж орсон орлого байна.

Нийт өр төлбөрөөс хугацаа хэтэрсэн, тооцоо нийлж баталгаажуулаагүй өглөг байхгүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Хими, хими технологийн хүрээлэн нь санхүүгийн тайланд нийгмийн даатгалын өглөгийг 16.0 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 41,497.6 сая төгрөг болж, 4,341.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	23,352,487.7	23,352,487.7	-
Хуримтлагдсан үр дүн	3,492,158.2	7,834,268.5	4,342,110.3
Өмнөх үеийн үр дүн	1,016,313.8	3,471,572.7	2,455,258.9
Тайлант үеийн үр дүн	2,475,844.4	4,362,695.8	1,886,851.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10,311,134.8	10,310,892.0	(242.8)
Дүн	37,155,780.7	41,497,648.2	4,341,867.5

Эх сурвалж: Шинжлэх ухааны академийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант оны үр дүн 4,362.7 сая төгрөг голлон нөлөөлсөн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт дансанд тайлант онд хөрөнгө акталж устгаснаас үүссэн дахин үнэлгээний зөрүү 0.2 сая төгрөг бүртгэж, тайлагнасан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2021 оны төсвийн төслийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 28,904.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв захирагчийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 24,069.2 сая төгрөгөөр баталж, 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар 397.6 сая төгрөгөөр бууруулан, 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 23,671.9 сая төгрөгөөр тодотгосон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 23,671.9 сая төгрөгийн төсөв батлагдаж, 23,671.9 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс урсгал зардлын санхүүжилтэд 23,654.9 сая, мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 1.1 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 0.6 сая, нийт 23,656.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 22,341.4 сая төгрөг буюу 94.4 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 911.8 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 239.3 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 30.5 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 28.0 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 80.3 сая, бараа, үйлчилгээний бусад зардлыг 26.7 сая төгрөгөөр дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Зарцуулагдаагүй үлдэгдэл 1,315.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт-10 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	70815	Шинжлэх ухаан технологи	23,671,917.5	22,341,364.5	1,330,553.0	94.4
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	21,909,391.9	20,624,322.2	1,285,069.7	94.1
1.2	80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зардал	123,918.2	101,632.5	22,285.7	82.0
1.3	80219	Харуул, хамгаалалтын зардал	559,399.5	541,166.4	18,233.1	96.7
1.4	80220	Холбооны суваг ашигласны хөлс	329,041.2	328,549.2	492.0	99.9
1.5	80226	Байр ашиглалтын үйлчилгээний зардал	142,160.2	139,970.0	2,190.2	98.5
1.6	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	596,577.2	594,595.5	1,981.7	99.7
1.7	80509	Гадаадын болон олон улсын гишүүнчлэлийн хураамж	11,429.3	11,128.7	300.6	97.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж 1,849.1 сая, Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгасан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 2,081.2 сая, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,169.7 сая нийт 6,100.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 5,445.3 сая, хөрөнгийн зардалд 60.9 сая, нийт 5,506.2 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 593.8 сая төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгасан 7 үзүүлэлтийн зорилтот түвшинд 23,671.9 сая төгрөг баталснаас гүйцэтгэлээр 94.4 хувийн биелэлттэй байна.

3.8 Аудитын гол асуудал

Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгүүдийн эрдэм шинжилгээний ажилтнууд тус хүрээлэнгүүдээс хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрт ажиллаж, давхар цалин авч байгааг зохицуулсан журам байхгүй байна.

3.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өмнөх аудитаар хүргүүлсэн шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг иж бүрэн хугацаанд нь байршуулах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант хугацаанд 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн

байх”, 4.1.2 “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг харьяа 14 нэгжид хийсэн аудитын дүнгээс нэгтгэхэд нийт 1,803.3 сая төгрөгийн 12 алдаа, зөрчил илэрч, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 албан шаардлага, хариуцлага тооцуулах 7 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлж ажилласан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Харьяа байгууллагуудад илэрсэн нийцлийн аудитын асуудлаар нийт 1,313.5 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 247.5 сая төгрөгийн 4 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 1,066.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмжийг өгсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй нийт 1,803.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн /Одон орон, геофизикийн хүрээлэн 32.4 сая, Физик, технологийн хүрээлэн 7.7 сая, Биологийн хүрээлэн 314.7 сая, Түүх, угсаатны зүйн хүрээлэн 292.4 сая, Олон улс судлалын хүрээлэн 605.8 сая, Хими, хими технологийн хүрээлэн 550.3 сая төгрөг/
- Төсвийн хэмнэлт үүсгээгүй 1,020.9 сая төгрөг /Одон орон, геофизикийн хүрээлэн 1,020.9 сая төгрөг/, нэмэлт санхүүжилтийн төсвөөс урсгал үйл ажиллагаанд 99.2 сая төгрөгийн зардал зарцуулсан. /Ботаникийн хүрээлэн 99.2 сая төгрөг/

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 99.2 хувьтай байна.

Хүснэгт.11 Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар тогтоосон акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	5	43526.2	5	43,526.2			100
Албан шаардлага	15	502,155.6	12	502,012.6	3	143.0	99.9
Зөвлөмж	40	374,511.2	39	374,511.2	1		97.5
Нийт дүн	60	920,193.0	56	920,050.0	4	143.0	99.2

Эх сурвалж: Шинжлэх ухааны академийн 2021 оны акт, албан шаардлага, зөвлөмжийн нэгтгэл

Олон улс судлалын хүрээлэн, Биологийн хүрээлэн, Хими, хими технологийн хүрээлэн шилэн дансны мэдээлэл хугацаандаа оруулаагүй албан шаардлага хэрэгжүүлээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгүүдэд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдээс хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнууд давхар цалин авч буй асуудлыг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,006.3 сая төгрөгийн 65 алдаа, зөрчил илэрснээс, 1,502.1 сая төгрөгийн 29 алдааг залруулж, 32.5 сая төгрөгийн 10 төлбөрийн акт тогтоож, 206.8 сая төгрөгийн 11 албан шаардлага хүргүүлж, 264.9 төгрөгийн алдаа зөрчилд 15 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн 499.1 сая төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 325.2 сая төгрөгөөс хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

4.1 Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 14 төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 10 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллагыг түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 8, “Хязгаарлалттай” 2 дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,006.3 сая төгрөгийн 65 алдаа, зөрчил илрүүлснээс 1,502.0 сая төгрөгийн 29 алдааг аудитын явцад залруулж, 32.5 сая төгрөгийн 10 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 206.8 сая төгрөгийн 11 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 264.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 15 зөвлөмжийг хүргүүллээ.

4.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч

4.2.1 Албан шаардлага

Тайлант онд докторын зэрэг хамгаалах ажлын хэсгийн гишүүдэд олгосон цалингаас 3.5 сая төгрөгийн Нийгмийн даатгалын шимтгэл суутган тооцоогүй, хувь хүний орлогын албан татварыг 0.2 сая төгрөгөөр, гарт олгох цалинг 1.5 сая төгрөгөөр тус тус илүү олгосон байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 “Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч болон ажил олгогч нь дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Шинжлэх ухааны академийн харьяа 14 хүрээлэнгийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар залруулагдаагүй 499.1 сая төгрөгийн 35 алдаа, зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37 “төсвийн төвлөрүүлэн захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг; 5 дугаар зүйлийн 5.1.3 санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх; 6 дугаар зүйлийн 6.6.1 “төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Дээрх албан шаардлагын биелэлтийг Үндэсний аудитын газарт 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Аудитын санал дүгнэлт						Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
			Үүнээс								Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
			Бүгд	Зөрчилгүй	Хязгаар	Сөрөг	Дүгнэлт агахаа	Түүвэрт хамруу	Тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	Дүн
1	Одон орон, геофизикийн хүрээлэн	АХГ-2022/49/НА-СТА-ТШЗ	1	1					3	304,009.7	3	304,009.7								
2	Физик, технологийн хүрээлэн	АХГ-2022/51/НА-СТА-ТШЗ	1	1					4	473,360.5	4	473,360.5								
3	Хэл зохиолын хүрээлэн	АХГ-2022/54/НА-СТА-ТШЗ	1	1					1	-								1		
4	Математик, тоон технологийн хүрээлэн	АХГ-2022/58/НА-СТА-ТШЗ	1		1				6	157,476.2	1	15,860.0	1	9,998.5				4	131,617.7	
5	Биологийн хүрээлэн	АХГ-2022/56/НА-СТА-ТШЗ	1	1					10	372,466.3	6	361,044.8	1	2,004.0	1			2	9,417.5	
6	Палеонтологийн хүрээлэн	АХГ-2022/59/НА-СТА-ТШЗ	1	1					3	319,335.1	3	319,335.1								
7	Түүх, угсаатны зүйн хүрээлэн	АХГ-2022/60/НА-СТА-ТШЗ	1		1				8	199,303.0			3	13,750.8	2	68,950.0		3	116,602.2	
8	Олон улс судлалын хүрээлэн	АХГ-2022/50/НА-СТА-ТШЗ	1	1					5	2,938.4	4	2,906.4						1	32.0	
9	Газарзүй, гео-экологийн хүрээлэн	АХГ-2022/48/НА-СТА-ТШЗ	1	1					3	-	2							1		
10	Хими, хими технологийн хүрээлэн	АХГ-2022/53/НА-СТА-ТШЗ	1	1					12	41,925.7	6	25,517.5	2	2,778.5	1	6,448.1		3	7,181.6	
11	Археологийн хүрээлэн	АХГ-2022/02/НА-СТА-ТТЗ	1					1	3	70,886.9			1	1,000.0	2	69,886.9				
12	Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн	АХГ-2022/02/НА-ТТЗ	1					1	3	18,665.5			1	1,500.0	2	17,165.5				
13	Геологийн хүрээлэн	АХГ-2022/02/НА-СТА-ТТЗ	1					1	3	40,781.8			1	1,500.0	2	39,281.8				
14	Философийн хүрээлэн	АХГ-2022/02/НА-СТА-ТТЗ	1					1	0	-										
15	ШУА-ийн аппарат	АХГ-2022/02/НА-СТА-ТТЗ	1					1	1	5,105.5					1	5,105.5				

**Шинжлэх ухааны академийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан**

ДҮН	15	8	2	0	0	5	65	2,006,254.6	29	1,502,034.0	10	32,531.8	11	206,837.8	0	0	15	264,851.0
------------	----	---	---	---	---	---	----	-------------	----	-------------	----	----------	----	-----------	---	---	----	-----------

5.2 Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
					Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
			Тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	Дүн
1	Одон орон, геофизикийн хүрээлэн	АХГ-2022/49/НА-СТА-ТШЗ	2	1,053,289.4							1	32,373.00	1	1,020,916.4
2	Физик, технологийн хүрээлэн	АХГ-2022/51/НА-СТА-ТШЗ	1	7,692.6							1	7,692.6		
3	Хэл зохиолын хүрээлэн	АХГ-2022/54/НА-СТА-ТШЗ	1	-							1			
4	Математик, тоон технологийн хүрээлэнгийн	АХГ-2022/58/НА-СТА-ТШЗ	2	144,048.0					1	129,679.1			1	14,368.9
5	Биологийн хүрээлэн	АХГ-2022/56/НА-СТА-ТШЗ	4	439,547.2					2	99,166.6	1	314,720.6	1	25,660.0
6	Палеонтологийн хүрээлэн	АХГ-2022/59/НА-СТА-ТШЗ	0	-										
7	Түүх, угсаатны зүйн хүрээлэн	АХГ-2022/60/НА-СТА-ТШЗ	2	311,034.7					2	311,034.7				
8	Шинжлэх ухааны академийн Олон улс судлалын хүрээлэн	АХГ-2022/50/НА-СТА-ТШЗ	1	605,790.7							1	605,790.7		
9	Газарзүй гео-экологийн хүрээлэн	АХГ-2022/48/НА-СТА-ТШЗ	2	5,022.0					1				1	5,022.0
10	Хими, хими технологийн хүрээлэн	АХГ-2022/53/НА-СТА-ТШЗ	1	550,291.3							1	550291.3		
11	Археологийн хүрээлэн	АХГ-2022/02/НА-СТА-ТТЗ	1	-					1					
12	Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн	АХГ-2022/02/НА-СТА-ТТЗ	1	-					1					
13	Геологийн хүрээлэн	АХГ-2022/02/НА-СТА-ТТЗ	1	-					1					
14	Философийн хүрээлэн	АХГ-2022/02/НА-СТА-ТТЗ	1	-					1					
15	ШУА-ийн эрдэмтэн нарийн бичиг	АХГ-2022/02/НА-СТА-ТТЗ	0	-										
ДҮН			20	3,116,715.9	-	-	-	-	10	539,880.4	6	1,510,868.2	4	1,065,967.3



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 425/А040064
425-2022/028/НН-СДН-ТБ

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.2-т заасны дагуу Шинжлэх ухааны академийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар хүргүүлсэн шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг иж бүрэн хугацаанд нь байршуулах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант хугацаанд 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, ил тод байдлыг ханган ажиллах, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлага хэрэгжүүлээгүй холбогдох албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч Д.Рэгдэлд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.НАРАНГЭРЭЛ
Ч.ДАШДАВАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 05 № 406/40140069
405-2022/02/118-018-725

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Шинжлэх ухааны академийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Докторын зэрэг хамгаалах ажлын хэсгийн гишүүдэд олгосон цалингаас 3,462,000.00 төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутган тооцоогүй, 164,350.00 төгрөгийн хувь хүний орлогын албан татвар, 1,479,150.00 төгрөгийн гарт олгох цалинг тус тус илүү олгосон байна.


Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч болон ажил олгогч нь дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нийгмийн даатгалын шимтгэлийг хуульд заасан хувь хэмжээгээр суутган тооцох, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч Д.Рэгдэл, Орлогч дарга бөгөөд санхүү, нийтлэг үйлчилгээний хэлтсийн дарга Б.Бат-Эрдэнэ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.НАРАНГЭРЭЛ
Ч.ДАШДАВАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 05

№

727/140140069

Улаанбаатар хот

447/2022/02/100-сгн-тб

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Шинжлэх ухааны академийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шинжлэх ухааны академийн харьяа 14 хүрээлэнгийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар залруулагдаагүй 499,115,100.0 төгрөгийн 35 алдаа, зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37 "төсвийн төвлөрүүлэн захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг; 5 дугаар зүйлийн 5.1.3 санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх; 6 дугаар зүйлийн 6.6.1 "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/96 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Алдаа, зөрчил гаргасан харьяа нэгжүүдийн санхүү, төсвийн үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, дотоод хяналтыг сайжруулахад анхаарч, илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид дээрх зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шинжлэх ухааны академийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Б.Авид, Орлогч дарга бөгөөд санхүү, нийтлэг үйлчилгээний хэлтсийн дарга Б.Бат-Эрдэнэ нарт даалгасугай.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.НАРАНГЭРЭЛ
Ч.ДАШДАВАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\19.10.10.20\Bichig_Thirreg\Alban Shaardlaga\2022\0325 Auditin 2 Газар-374.Docx

2022.03.05
10:15:20.136

701081862



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2022 оны 03 дугаар сарын 25 № 147/40170069

Улаанбаатар хот

451-0222/02/14-СТД-713

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Археологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн аудитын байгууллагаас тус байгууллагын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн хийх хуваарьтай байсан боловч тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудитыг аудитын хуулийн этгээдээр гүйцэтгүүлж 1,000,000.00 төгрөг шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Монгол Улсын Ерөнхий аудиторовын санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалт, аудит хийх хэлбэр батлах тухай А/64 дүгээр тушаалтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зориулалт бусаар зарцуулсан 1,000,000.00 /Нэг сая/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Археологийн хүрээлэнгийн захирал Г.Эрэгзэн, нягтлан бодогч Д.Бадамханд нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.НАРАНГЭРЭЛ
Ч.ДАШДАВАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тогируу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

9006109
9019120396

Z:\Arh\2022\9325_Auditin 2 Gazar-80.Docx

0001090351



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 05

№ 714/40170069

Улаанбаатар хот

ХТГ-2022/05/19 - 078-113

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Археологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 119 мэдээллийг ил тод байршуулахаас 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4 "төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны мэдээллийг тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Археологийн хүрээлэнгийн захирал Г.Эрэгзэн, нягтлан бодогч Д.Бадамханд нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.НАРАНГЭРЭЛ
Ч.ДАШДАВАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25

№ 118/10140869

Улаанбаатар хот

АХТ-2022/02/118-СТН-118

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Археологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эцэст 20,000,000.00 төгрөгийн шатахууны талон худалдан авч хангамжийн материалын үлдэгдлээр тайлагнасан байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 7 дугаар зүйлийн 7.7 "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж зарцуулан, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Археологийн хүрээлэнгийн захирал Г.Эрэгзэн, нягтлан бодогч Д.Бадамханд нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.НАРАНГЭРЭЛ
Ч.ДАШДАВАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 08 дугаар сарын 25 № 719/4017-0059
415-2022/08/14-СН

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.2-т заасны дагуу Археологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус хүрээлэн нь археологийн дурсгал, олдворыг илрүүлэх, хамгаалах, судлан шинжлэх чиглэлээр хэрэгжүүлсэн төслүүдэд 198,100,000.00 төгрөгийн цалин олгож, ажилтнаас суутгах 22,800,000.00 төгрөг, ажил олгогчоос суутгах 24,800,000.00 төгрөг, нийт 47,600,000.00 төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутган тооцоогүй, хувь хүний орлогын албан татварыг 2,300,000.00 төгрөгөөр илүү суутгасан байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1.1 "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21.1 "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй, оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цалингаас суутгах татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлж байх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Археологийн хүрээлэнгийн захирал Г.Эрэгзэн, нягтлан бодогч Д.Бадамханд нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.НАРАНГЭРЭЛ
Ч.ДАШДАВАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу 3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-204230

Z:\Alban Shaardlaga\2022\0325 Auditin 2 Gazar-358.Docx

0001081822



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 09 дугаар сарын 25

№ 148/2022-0069

Улаанбаатар хот

ХТ - 2022/02/14 - СГА - ТБ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн аудитын байгууллагаас тус байгууллагын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн хийх хуваарьтай байсан боловч тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудитыг аудитын хуулийн этгээдээр гүйцэтгүүлж 1,500,000.00 төгрөг шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Монгол Улсын Ерөнхий аудиторын Санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалт, аудит хийх хэлбэр батлах тухай А/64 тоот тушаалтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зориулалт бусаар зарцуулсан 1,500,000.00 /Нэг сая таван зуун мянга/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн захирал И.Түвшинтогтох, нягтлан бодогч Л.Мөнхцэцэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.НАРАНГЭРЭЛ
Ч.ДАШДАВАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25

№ 412/40140069

Улаанбаатар хот

412-2022/02/НН-СЭ-ТБ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн захирал тайлант онд үндсэн цалингаас гадна тус хүрээлэнгийн хэрэгжүүлсэн 3 төслөөс нийт 8,103,549.00 төгрөгийн цалин авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дахь заалт "Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар, төлөвлөж зарцуулах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн захирал И.Түвшинтогтох, нягтлан бодогч Л.Мөнхцэцэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.НАРАНГЭРЭЛ
Ч.ДАШДАВАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25

№ 221/40140069

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн нь тайлант онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 119 мэдээллийг ил тод байршуулахаас 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4 "төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны мэдээллийг тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн захирал И.Түвшинтогтох, нягтлан бодогч Л.Мөнхцэцэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.НАРАНГЭРЭЛ
Ч.ДАШДАВАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25

№ 7322/40170069

Улаанбаатар хот

ХТ-2022/03/14 - СТА-73

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эцэст 9,062,000.00 төгрөгийн шатахууны талон худалдан авч хангамжийн материалын үлдэгдлээр тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 7 дугаар зүйлийн 7.7 "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, төсвийн зарцуулаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлж байх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн захирал И.Түвшинтогтох, нягтлан бодогч Л.Мөнхцэцэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.НАРАНГЭРЭЛ
Ч.ДАШДАВАА

2001091834



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2022 оны 03 дугаар сарын 25 № 151/Н01Н0069
151-0002/001/НА-СТН-ТБ

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Геологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн аудитын байгууллагаас тус байгууллагын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн хийх хуваарьтай байхад аудитын хуулийн этгээдээр санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулж 1,500,000.00 төгрөг шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Монгол Улсын Ерөнхий аудиторовын санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалт, аудит хийх хэлбэр батлах тухай А/64 тоот тушаалтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зориулалт бусаар зарцуулсан 1,500,000.00 /Нэг сая таван зуун мянга/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Геологийн хүрээлэнгийн захирал Д.Одгэрэл, нягтлан бодогч Б.Соёлмаа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.НАРАНГЭРЭЛ
Ч.ДАШДАВАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойргуу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

10.10.10.20\Bichig_Khereg\Akt\2022\0325 Auditin 2 Газар-83.Docs

9006109
9019120396

0001090356



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 423/АМН-00069
АДГ-2022/002/НН-СН-ТБ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Геологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Геологийн хүрээлэн тайлант онд 7 төсөл хэрэгжүүлж, цалингийн зардалд 13,700,000.00 төгрөг зарцуулж, ажил олгогчоос төлөх 1,649,271.00 төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг ажилтны цалингаас суутган төлсөн.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 4 дэх хэсэгт заасан даатгуулагч болон ажил олгогч нь дөр дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг хуульд заасан хувь хэмжээгээр тооцож, ажил олгогчоос төлж байх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Геологийн хүрээлэнгийн захирал Д.Одгэрэл, нягтлан бодогч Б.Соёлмаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.НАРАНГЭРЭЛ
Ч.ДАШДАВАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 05 № 724/А017 0069
А01-2022/002/НН-СН-ХЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Геологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн хөрөнгөөр 37,632,500.00 төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж худалдан авсан байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Геологийн хүрээлэнгийн захирал Д.Одгэрэл, нягтлан бодогч Б.Соёлмаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.НАРАНГЭРЭЛ
Ч.ДАШДАВАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2022\0325 Auditin 2 Gazar-356.Docx

0001081818



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2022 оны 03 дугаар сарын 25

№

149/ААТ0069

Улаанбаатар хот

АТ-2022/02/18 - СТ-118

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн аудитын байгууллагаас тус байгууллагын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн хийх хуваарьтай байсан боловч тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудитыг аудитын хуулийн этгээдээр гүйцэтгүүлж 2,500,000.00 төгрөг шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Монгол Улсын Ерөнхий аудиторовын санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалт, аудит хийх хэлбэр батлах тухай" А/64 дүгээр тушаалтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зориулалт бусаар зарцуулсан 2,500,000.00 /Хоёр сая таван зуун мянга/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкн дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн захирал Ц.Цэрэндорж, нягтлан бодогч О.Баярсайхан нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.НАРАНГЭРЭЛ
Ч.ДАШДАВАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-263330

9006109
9019120396

Z:\AKT\2022\0325 Auditlm 2 Газар-77.Docx

0001030344